

ТАНИН МЭДЭХҮЙН СЭТГЭЛ ЗҮЙГ БОЛОВСРОЛЫН ПРАКТИКТ АШИГЛАХ

З.Энхзаяа¹, Б.Баярмаа¹, Э.Уянга¹, Д.Энхмаа¹, Б.Лагшмаа¹, В.Энхтуяа¹

¹МАУОУС, АШУУИС

enkhzaya.z@mnums.edu.mn

Хүлээн авсан огноо: 2021.10.22

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор О.Отгонтогоо

Үндэслэл

Танин мэдэхүйн сэтгэл судлал нь хүртэхүй, анхаарал, ой тогтоолт, хэл яриа, сэтгэхүй, ойлголтын бүтэц, асуудлыг шийдвэрлэх, хийсвэр оюун ухаан зэрэг асуудлуудыг шинжилдэг. Танин мэдэхүйн сэтгэл судлалыг боловсролын хэрэглээ болгож сургалтын үр дүнг нэмэгдүүлэх боломжтой. Үүний тулд багш нар сургалтанд нөлөө үзүүлэх сэтгэл судлалын зарчим, сургалтын төрөл зүйлүүдийг мэдэж байх шаардлагатай. Мөн суралцагчдын чадвар, сонирхол, тулгамдаж буй асуудлууд, бие хүний зан чанар болон хэрхэн ажиллавал суралцагч илүү сайн сурах зэргийг ойлгож байх нь зүйтэй.

Түлхүүр үг: Танин мэдэхүйн сэтгэл судлал, боловсрол, ой санамж

Зорилго, зорилт

Сургалтын хөтөлбөрийн хүрээнд суралцагчийн мэдлэг, чадвар, хандлага чадамжийг нэмэгдүүлэх, багшийн заах арга зүйг хөгжүүлэх. Судалгааны материал, арга зүй: Харвардын их сургуулийн багш суралцагчдаа дэмжих Дерек Бок сургалтын төв Калифорнийн их сургуулийн сэтгэл судлалын профессор Роберт Аллен Бьорк нарын суралцагчдын сурах чадвар, ой санамж, сургах, сургахад суралцах шинжлэх ухааны үр дагаварт хийсэн судалгааны арга зүйгээс тоймлон судалсан.

Үр дүн

Сургалтын арга зүйг шийдвэрлэн суралцагчдыг сэдэлжүүлэх. Сургалтыг сэдэлжүүлэх арга нь суралцагчдад гэнэт их хэмжээний мэдээлэл өгөхөөс зайлсхийх, алхам алхмаар бага зэргийн мэдээллийг хүргэх нь тэднийг сэдэлжүүлж амжилтанд хүргэх, мөн үүнтэй адил суралцагчдын сэдлийн буюу идэвхийн төвшин нь хэт хүчилсэн биш, харин дундаж байхад сургалт илүү ойлгомжтой байна. Танин мэдэхүйн сэтгэл судлалын «мэдээлэл авах» (кодлох), түүнийг хэрхэн хадгалах, хэрхэн «буцааж гаргах» (мэдлэгийг эргүүлэн татах) гэсэн процессуудыг багшид ойлгуулах, эдгээр алхмуудыг ашигласнаар багш нар шинэ мэдээллээ хэзээ танилцуулах, мөн цээжлэх мэдээллийг тодруулах, мэдээллийг хадгалж үлдэхийн тулд даалгавруудыг

хэрхэн дараалуулан өгөх талаар ойлголттой болж, сурагчдын сурахад дэмжлэг үзүүлэх юм.

Дүгнэлт

Танин мэдэхүйн сэтгэл судлалын аргуудыг сургалтад үр дүнтэй ашиглаж суралцагчдын үр чадвар, мэдлэг, хандлагыг сайжруулах нь чухал ач холбогдолтой юм. Сургагч багш нь анагаах ухааны мэдлэг, эмнэлзүйн үр чадвараас гадна харилцааны үр чадвар, сурган заах аргазүйн чадваруудыг эзэмшсэн байх шаардлагатай.